



**МОНГОЛ УЛС**  
**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ**  
**ТОГТООЛ**

2011 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 383

Улаанбаатар хот

Г “Баруун бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ” ХК-ийн ᠗  
үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.7, Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйл, Хорооны 2009 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай журам”-ын 7.1 дэх заалт, “Баруун бүсийн эрчим хүчний систем” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн хурлын 2010 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Баруун бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ” ХК-ийн оноосон нэрийг “Баруун бүсийн эрчим хүчний систем” ХК болгон өөрчилж үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар/Б.Саруул/, хөрөнгийн биржийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК/Х.Алтай/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулахыг “ҮЦТТТХТ” ХХК/Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. “Баруун бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ” ХК-ийн гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 66,925,112 /жаран зургаан сая есөн зуун хорин таван мянга нэг зуун арван хоёр/ ширхэг энгийн хувьцааг хувь нийлүүлсэн хөрөнгө нэмэгдүүлсэнтэй холбогдуулан 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 31,322,459 /гучин нэгэн сая гурван зуун хорин хоёр мянга дөрвөн зуун тавин ес/ ширхэг байхаар үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөн бүртгэхийг Үнэт цаасны газар/Б.Саруул/, Хөрөнгийн биржийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК/Х.Алтай/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТТТХТ” ХХК/Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

3. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол

ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Баруун бүсийн эрчим хүчний систем” ХК/Б.Нямсамбуу/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар/Б.Саруул/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар/Д.Нямцэрэн/-г тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН